



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 07 сарын 03 өдөр

Дугаар 303

Улаанбаатар хот

Г Журамд өөрчлөлт оруулах тухай Г

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Даатгалын тухай хуулийн 12¹ дугаар зүйлийн 12^{1.7}, Жолоочийн даатгалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 331 дүгээр тогтоолоор батлагдсан “Жолоочийн даатгалын хураамжийн хэмжээг тооцох итгэлцүүр хэрэглэх журам”-ын 2 дугаар зүйлийн 2.2. дахь хэсгийн 2.2.1, 2.3 дахь хэсгийн 2.3.1, 2.3.3, 2.4 дэх хэсгийн 2.4.1, 2.8 дахь хэсгийн 2.8.1 дэх заалтуудад доор дурдсанаар өөрчлөлт оруулсугай:

1/ 2 дугаар зүйлийн 2.2 дэх хэсгийн 2.2.1 дэх заалт:

2.2.1. И₁ нь дараах хэмжээтэй байна:

| Тээврийн хэрэгслийг ашиглах газар нутгийн байршил | И ₁ |
|---|----------------|
| Улаанбаатар хот | 1.2 |
| Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ, Төв аймаг | 1.1 |
| Бусад аймаг, хот | 1.0 |

2/ 2 дугаар зүйлийн 2.3 дахь хэсгийн 2.3.1 дэх заалт:

2.3.1. И₂ нь дараах хэмжээтэй байна:

| Даатгалын гэрээ эхлэх үеийн бүлэг | И ₂ | Өмнөх 1 жилийн хугацаанд даатгуулагчийн буруугаас үүссэн даатгалын тохиолдлын үед нөхөн төлбөр олгосон тоо, эсхүл тухайн тээврийн хэрэгслийг жолоодох жолоочийн буруугаас үүссэн зам тээврийн ослын улмаас жолоочийн даатгалын сангаас нөхөн төлбөр олгосон тооноос хамаарах бүлэг | | | | | | | |
|-----------------------------------|----------------|--|----------------|----------------|----------------|----------------|--|--|--|
| | | 0 удаа олгосон | 1 удаа олгосон | 2 удаа олгосон | 3 удаа олгосон | 4 удаа олгосон | | | |
| | | | | | | | | | |

000910

| | | | | | | |
|----|------|----|---|---|---|---|
| M | 2.45 | 0 | M | M | M | M |
| 0 | 2.30 | 1 | M | M | M | M |
| 1 | 1.55 | 2 | M | M | M | M |
| 2 | 1.40 | 3 | 1 | M | M | M |
| 3 | 1.00 | 4 | 1 | M | M | M |
| 4 | 0.95 | 5 | 2 | 1 | M | M |
| 5 | 0.90 | 6 | 3 | 1 | M | M |
| 6 | 0.85 | 7 | 4 | 2 | M | M |
| 7 | 0.80 | 8 | 4 | 2 | M | M |
| 8 | 0.75 | 9 | 5 | 2 | M | M |
| 9 | 0.70 | 10 | 5 | 2 | 1 | M |
| 10 | 0.65 | 11 | 6 | 3 | 1 | M |
| 11 | 0.60 | 12 | 6 | 3 | 1 | M |
| 12 | 0.55 | 13 | 6 | 3 | 1 | M |
| 13 | 0.50 | 13 | 7 | 3 | 1 | M |

3/ 2 дугаар зүйлийн 2.3 дахь хэсгийн 2.3.3 дахь заалт:

“2.3.3. Жолоочийн даатгалын гэрээ байгуулахад өмнөх 1 жилийн хугацаанд даатгуулагчийн буруугаас үүссэн тохиолдлын үед нөхөн төлбөр олгосон тоо, эсхүл тухайн тээврийн хэрэгслийг жолоодох жолоочийн буруугаас үүссэн зам тээврийн ослын улмаас жолоочийн даатгалын сангаас нөхөн төлбөр олгосон тоог харгалзан даатгуулагчийн бүлгийг тогтооно.”

4/ 2 дугаар зүйлийн 2.4 дэх хэсгийн 2.4.1 дэх заалт:

2.4.1. И₃ нь дараах хэмжээтэй байна:

| Даатгалын баталгаанд дурдсан жолоочийн нас, автотээврийн хэрэгсэл жолоодох туршлага | И ₃ |
|--|----------------|
| 25 хүртэлх насны, 3 жил хүртэлх туршлагатай | 1.2 |
| 25 хүртэлх насны, 3 жилээс дээш туршлагатай | 1.15 |
| 25-оос дээш насны, 3 жил хүртэлх туршлагатай | 1.1 |

| | |
|--|-----|
| 25-оос дээш насны, 3 жилээс дээш туршлагатай | 1.0 |
|--|-----|

5/ 2 дугаар зүйлийн 2.8 дэх хэсгийн 2.8.1 дэх заалт:

2.8.1. И₇ нь дараах хэмжээтэй байна:

| Тээврийн хэрэгслийн ангилал, зориулалтын төрөл | | И ₇ |
|---|---|----------------|
| <u>В ангилал</u> <i>Хөдөлгүүрийн багтаамж /см³/</i> | -1000 хүртэл | 0.9 |
| | -1001-2000 | 1.0 |
| | -2001-3000 | 1.1 |
| | -3001-4000 | 1.2 |
| | -4001-с дээш | 1.3 |
| <u>С ангилал</u> <i>Тээврийн хэрэгслийн даац</i> | -8 тонн хүртэлх даацтай | 1.0 |
| | -8 болон түүнээс дээш тоннын даацтай | 1.3 |
| <u>Д ангилал</u> <i>Суудлын тоо</i> | -16 хүртэлх зорчигчийн суудалтай | 1.0 |
| | -16 болон түүнээс дээш зорчигчийн суудалтай | 1.3 |

2. Журамд оруулсан өөрчлөлтийг 2015 оны 8 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

3. Журамд өөрчлөлт орсонтой холбогдуулан шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг Албан журмын даатгагчдын холбоо /Б.Нямдорж/-нд үүрэг болгосугай.

4. Журамд өөрчлөлтийг оруулж, хэрэгжилтэд хяналт тавьж, нийтэд мэдээлж ажиллахыг Ажлын алба /Б.Батсэлэнгэ/-нд даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА